Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн эрх зүйн зохицуулалт болон Гэрээнд санал болгож буй жишиг заалт

Ерөнхий танилцуулга

Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын (цаашид "Танхим" гэх) даргын 2020 оны 1 сарын 24-ний өдөр баталсан force majeure /Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл/ болон hardship /хүнд нөхцөл байдал/-ыг гэрчлэх журмын 1.2.1 –д заасны дагуу:

Force majeure буюу гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл (Цаашид force majeure гэх) гэдэгт талуудын хараа хяналтаас гадуур болсон, урьдчилан таамаглах боломжгүй, урьдчилан сэргийлж, шинжлэх ухаан, техникийн ололтыг ашиглан даван гарах боломжгүй дараах саад тотгор тохиолдсоны улмаас талууд гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлж чадахгүйд хүрэхийг ойлгоно:

1. Зарласан болон зарлаагүй дайн, зэвсэгт мөргөлдөөн, бослого, гадаадын түрэмгийлэл, хорлон сүйтгэх үйл ажиллагаа, хувьсгал;
2. Байгалийн бүх төрлийн гамшиг /хүчтэй салхи шуурга, хар салхи, газар хөдлөлт, хүчтэй давалгаа, үер, цас, зуд, ган гачиг, их хэмжээний бороо, аянга цахилгаан, гал түймэр гэх мэт/;
3. Тэсрэлт, дэлбэрэлт, машин, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн эвдрэл, цахилгаан ноцтой гэмтэл;
4. Бүх төрлийн хязгаар хориг, өвчин тахал, хорио цээр, хариуцлагаас чөлөөлөгдөх хүсэлтэй аж ахуйн нэгжид тохиолдсон ажил зогсолт, ажил хаялт;
5. Төрийн албан тушаалтны хуулийн дагуух болон хууль бус үйлдэл, эс үйлдэл, эрх зүйн акт, тушаал, захирамж, ажлын байр татан буугдах, эд хөрөнгө дайчлан хураах, нийгэмчлэх зэрэг орно.

Танхим нь гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийг гэрчилдэг.

Force majeure –тай холбоотой Гэрчилгээ[1] авахыг хүсэж байгаа хүсэлт гаргагч дараах шаардлагыг хангана:

- Талуудын байгуулсан гэрээнд force majeure-ийн заалтыг тусгасан байх;
- Гэрээ болон түүнтэй холбогдох гэрчилгээ гаргахад шаардлагатай баримтуудыг үнэн зөв, бүрэн гаргаж өгөх.

Танхим дараахи тохиолдолд гэрчилгээ олгохгүй:

[1] Гэрчилгээ гэдэгт МҮХАҮТ-аас хувь хүн, байгууллага force majeure болон хүнд нөхцөлд орсныг гэрчилж баталгаажуулж байгаа баримт бичиг.

- Хүсэлт гаргагчид тохиолдсон үйл явдал, нөхцөл байдал нь талуудын байгуулсан гэрээ болон энэ журамд заасан force majeure-ийн тохиолдолд хамаарахгүй;
- Хүсэлт гаргагч шаардлагатай баримт бичиг болон мэдээллийг бүрдүүлээгүй;
- Танхимын force majeure болон hardship-ийн зөвлөл гэрчилгээ гаргах шаардлагагүй гэж үзсэн.

Эрх зүйн зохицуулалт

Худалдах худалдан авах гэрээ:

1980 оны 4 дүгээр сарын 11-ний өдөр батлагдсан “Бараа худалдах-худалдан авах олон улсын гэрээний тухай” НҮБ-ын конвенцид Монгол улс 1997 онд нэгдэн орсон. Энэхүү конвенцийн 79 дүгээр зүйлд заасны дагуу “Аль нэг тал үүргээ гүйцэтгээгүй нь түүний хяналтаас гадна орших саад бэрхшээлээс болсон бөгөөд гэрээ байгуулах үед уг саад бэрхшээлийг тооцох, түүнээс зайлсхийх буюу түүний үр дагаврыг нь давж гарах арга замыг урьдчилан тооцох аргагүй байсныг дээрх тал тус тус нотолбол тухайн тал үүрэг гүйцэтгээгүйн хариуцлагыг хүлээхгүй” гэсэн зохицуулалт байдаг.

Харин Монгол улсын иргэний хуулийн 255.1.3-д заасны дагуу “Тухайн эд хөрөнгийн доголдол нь худалдан авагч түүнийг тээвэрлэх, хадгалах, ашиглах журам зөрчсөнөөс, force majeure-ийн шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас үүссэн тохиолдолд худалдан авагч шаардлага гаргах эрхээ алдана”.

Арилжааны гэрээ:

2016 оны ЮНИДРУА-гийн олон улсын арилжааны гэрээний зарчмын 7.1.7 – д заасны дагуу “Хэрэв гэрээний үүргээ биелүүлээгүй тал ийнхүү үүргээ биелүүлээгүй нь түүний хяналтаас гадуур болсон бөгөөд гэрээ байгуулах үед урьдчилан таамаглах боломжгүй буюу даван туулах боломжгүй байснаас болсон гэдгийг нотолбол хариуцлагаас чөлөөлөгдөнө” гэж заасан.

Энэхүү ЮНИДРУА-гийн зарчим нь заншлын эрх зүйгээр зохицуулагддаг тул аливаа арилжааны гэрээнд хэрэглэгдэж болно.

Түрээсийн гэрээ:

Force majeure-ийн шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас түрээсэлсэн эд хөрөнгийн чанар байдал алдагдвал талууд харилцан тохиролцож түрээсийн төлбөрийн хэмжээг өөрчилж болно.

Үйлчилгээ үзүүлэх гэрээ:

Монгол улсын Иргэний хуулийн 356 дугаар зүйлд заасны дагуу Гүйцэтгэсэн ажлын үр дүнг захиалагчид шилжүүлэхээс өмнө force majeure-ийн шинжтэй нөхцөл байдлын улмаас тухайн ажлын үр дүн устсан, гэмтсэн тохиолдолд бий болох эрсдэлийг ажил гүйцэтгэгч хариуцна. Харин гүйцэтгэсэн ажлын үр дүнг захиалагч хугацаанд нь хүлээн аваагүй бол

ажлын үр дүн ажил гүйцэтгэгчийн эзэмшилд байсан ч гэсэн force majeure-ийн шинжтэй нөхцөл байдлын улмаас бий болох үр дагаврыг захиалагч хариуцна.

Гэм хор

Монгол улсын Иргэний хуулийн 499 дугаар зүйлд заасны дагуу "Агаарынхаас бусад тээврийн хэрэгслийг ашиглах явцад force majeure-ийн шинжтэй онцгой нөхцөл байдал үүссэнээс гэм хор учирсан бол тээврийн хэрэгсэл эзэмшигч хохирлыг нөхөн төлөх үүрэг үүсэхгүй" г.м.

COVID-19 *эсрэг хэрэгжүүлж буй Монгол улсын арга хэмжээнүүд*

COVID-19 (2019-nCoV) цар тахлын тархалтаас урьдчилан сэргийлж Монголын улсын Засгийн газар дараах арга хэмжээг авааД байна:

1. Засгийн газрын 2020 оны 01 сарын 26-ны өдрийн 30 дугаар тогтоолоор бүх шатны боловсролын байгууллага, сургалтын төвийн үйл ажиллагааг 2020 оны 1 дүгээр сарын 27-ны өдрөөс 3 дугаар сарын 30-ны өдрийг хүртэл түр зогсоосон. Энэхүү түр зогсолтыг Улсын онцгой комиссын даргын 2020 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 13 дугаар тогтоолоор 2020 оны 4 дүгээр сарын 30 хүртэл сунгасан.
2. Нийслэл Засаг дарга 2020 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр А/108 дугаар захирамжаар дараах үйл ажиллагааг 2020 оны 01 дүгээр сарын 27-ны өдрөөс 2020 оны 03 дугаар сарын 02-ны өдрийг хүртэл түр зогсоосон. Үүнд:
   - Жагсаал цуглаан бүртгэх;
   - Олон нийтийг хамарсан хурал цуглаан, сургалт, спортын тэмцээн уралдаан, аялал зугаалга, урлаг, соёл, кинотеатр, жолооны курс, цахим болон төрөл бүрийн тоглоомын газрын үйл ажиллагаа.

   COVID – 19 халдварын дэгдэлтээс урьдчилан сэргийлэх, зогсоохтой холбоотойгоор энэхүү түр зогсолт 2020 оны 03 дугаар сарын 30-ны өдрийг хүртэл сунгасан.
3. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 39 дугаартай тогтоолоор Монгол улс, БНХАУ-ын хилийн агаарын зам, төмөр зам, авто замын бүх боомтоор БНХАУ-н иргэд болон тус улсаас ирж байгаа гуравдагч орны иргэн, харьяалалгүй хүнийг МУ руу нэвтрүүлэх хөдөлгөөнийг 2020 оны 03 дугаар сарын 02-ны өдрийг хүртэл зогсоосон байсан. Шилжилт хөдөлгөөний хугацааг 2020 оны 03 дугаар сарын 30-ны өдөр хүртэл сунгасан.
4. Монгол Улсын Засгийн газар 2020 оны 02 дугаар сарын 12-ны 62 дугаар тогтоолоор улсын хэмжээнд 2020 оны 02 дугаар сарын 13-ны өдрөөс 2020 оны 03 дугаар сарын 02-ны өдөр хүртэлх хугацаанд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлж, цагаан сарыг тэмдэглэхгүй байх нь зүйтэй гэж үзсэн. Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг шилжүүлсэн хугацааг Улсын онцгой

комиссын даргын 2020 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 13 дугаар тогтоолоор 2020 оны 4 дүгээр сарын 30 хүртэл сунгасан.

5. Улсын онцгой комиссын даргын 2020 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 02 дугаар тогтоолоор:
    - БНСУ болон Японоос Монгол руу ирэх 2 хуваарьт нислэгийг түр зогсоосон хугацааг 2020 оны 2 дугаар сарын 27-оос 2020 оны 03 дугаар сарын 11-ний өдрийг дуустал нислэгийг зогсоосон. Улсын онцгой комиссын даргын 2020 оны 03 дугаар сарын 8-ны өдрийн 4 дугаар тогтоолоор 2020 оны 03 дугаар сарын 28-нийг хүртэл сунгасан.
    - БНСУ, Япон, Иран улсад сүүлийн 14 хоног зорчсон гадаадын иргэдийг МУ-н хилээр нэвтрүүлэхгүй байх мөн эдгээр улсаас эх орондоо буцаж ирэх Монгол улсын иргэдийг улсын хилээр нэвтэрсэн өдрөөс эхлэн 14 хоногийн хугацаанд түр тусгаарлагдана.
6. Улсын онцгой комиссын 2020 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 5 дугаар тогтоолоор Монголд коронывируст халдварын анхны тохиолдолд илэрсэнтэй холбогдуулан хот хоорондын зорчигч тээвэр болон хувийн тээврийн хэрэгсэл, орон нутгийн хуваарьт нислэг, суудлын галт тэрэгний хөдөлгөөнийг 2020 оны 03 дугаар сарын 10-ны өдрөөс 2020 оны 03 дугаар сарын 16 хүртэл түр зогсоосон.

7. Улсын онцгой комиссын даргын 2020 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 06 дугаар тогтоолоор:
    - ОХУ, Касакстан, Туркаас Монгол ирэх хуваарьт нислэгийг 2020 оны 03 дугаар сарын 11-ноос 2020 оны 03 дугаар сарын 28-ны өдрийг дуустал түр зогсоосон.
    - ОХУ руу зорчих Монгол улсын иргэн болон ОХУ-аас Монгол руу зорин ирэх гадаад иргэн, харьяалалгүй хүний хөдөлгөөнийг 2020 оны 03 дугаар сарын 11-ний өдрөөс 2020 оны 03 дугаар сарын 30-н хүртэл зогсоосон.
    - 2020 оны 03 дугаар сарын 30-ны өдрийг дуустал жирэмсэн, 0-12 насны хүүхэдтэй эмэгтэй ажилтан, албан хаагчийг гэрээсээ ажиллах нөхцөл боломжоор хангах, цалинтай чөлөө олгоно.
8. 2019 оны 06 дугаар сарын 10-нд батлагдсан А/155 – 134 дугаартай **“**Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам**”-**ийн зээлийн ангилал, эргэн төлөлтөд түр хугацааны өөрчлөлт оруулж, “Ипотек, цалин, тэтгэвэр болон бусад хэрэглээний зээл хэлбэрээр иргэнд олгосон зээлийн эргэн төлөх хугацааг дараах ангиллын дагуу түр хойшлуулсан.
    - “Хэвийн” зээлийн хувьд 15 хүртэлх хоногийн эргэн төлөлтийг 90 хүртэлх хоног болгох,
    - “Анхаарал хандуулах” зээлийн хувьд эргэн төлөлтийг 91-120 хоногийн дотор төлөх,

- “Чанаргүй” зээлийн хувьд эргэн төлөлтийг 121-ээс дээш хоног байхаар тус тус тогтоох” шийдвэрийг гаргасан.

9. Улсын онцгой комиссын даргын 2020 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 13 дугаар тогтоолоор олон улсын хувиарт нислэг, төмөр замын олон улсын зорчигч тээврийн хөдөлгөөнийг түр зогсоосон хугацааг 2020 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр хүртэл сунгасан.

Санал болгож буй гэрээний жишиг заалт

1. Энэхүү гэрээнд **Force Majeure** /гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл/ гэдгийг гэрээний талуудын хяналтаас гадуур урьдчилан таамаглах боломжгүй, талууд гэрээгээр хүлээх үүргээ биелүүлэх боломжгүй нөхцөл байдлыг ойлгох бөгөөд үүнд газар хөдлөлт, хүчтэй салхи, түймэр аянга, үер, ган зэрэг байгалийн гамшиг, цацраг идэвхт бодитын хордуулалт, олон улсын шинжтэй хил боомт хаагдах /аль нэг талдаа/, хөдөлмөрийн маргаанаас үүдсэн өргөн хэмжээний эмх замбараагүй байдал, ажил хаялт, аж үйлдвэрийн бусад үйл явдал, тахал, дайн, дайн бүхий байдал, хорио цээр, газрын агентлагуудын бусад арга хэмжээ орох /үүгээр хязгаарлагдахгүй/ зэрэг нийгмийн онцгой байдал зэрэг хамаарна. Давагдашгүй хүчин зүйл нь аль нэг талын буюу тухайн талын төлөөлөгч, ажилтны хайхрамжгүй байдал, санаатай үйлдлийн улмаас үүссэн аливаа үйл явдал хамаарахгүй.
2. Аль нэг тал нь хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд энэхүү гэрээ зөрчсөн гэж үзэхгүй ба давагдашгүй хүчин зүйлд өртсөн тал нь энэхүү гэрээний болзол, нөхцөлийг хэрэгжүүлэх бүх урьдчилан сэргийлэх арга хэмжээ, боломжит хувилбарт арга хэмжээнүүдийг авсан боловч нэг Тал нь хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд гэрээг зөрчсөн гэж үзэхгүй.
3. Давагдашгүй хүчин зүйлд өртсөн тал гэрээний үүргээ хэрэгжүүлэх боломжгүй болсон тохиолдолд үүнээс гарах үр дагавар болон гэрээг хамгийн бага хугацаагаар хойшлуулах бүх арга хэмжээг авна.
4. Талууд гэрээний үүргийн гүйцэтгэлийг давагдашгүй хүчний шинжтэй аливаа нөхцөл байдлын улмаас түдгэлзүүлэх эрхтэй бөгөөд ингэхдээ тухайн нөхцөл байдал үүргийн гүйцэтгэлийг саатуулсан хугацаа, хэмжээнд түдгэлзүүлнэ. Дээрх нөхцөл байдлын нөлөөнд өртсөн Тал нь үүргийн гүйцэтгэлийг түдгэлзүүлэх тухай мэдэгдлийг нөгөө Талд хугацаа алдалгүй өгөх ба ийнхүү түдгэлзүүлэх болсон шалтгаан, хугацаа, шинж чанарыг мэдэгдэнэ.

Товч дүгнэлт

Короновирусын тархалт намжих эсэх нь тодорхойгүй байгаатай холбогдуулан шинээр гэрээ байгуулах болон гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулахдаа force majeure-ийн заалтыг тодорхой,

нарийвчлан тусгах шаардлагатай. Ингэснээр ирээдүйд бий болох болон одоо тохиолдож байгаа талуудын хяналтаас гадуур, урьдчилан харах боложгүй нөхцөл байдалд эрсдэлээс хамгаалах болон давагдашгүй хүчин зүйлийн үед гэрээгээр хүлээсэн үүргээс чөлөөлөгдөх эрх зүйн урьдач нөхцлийг хангана.

Дэлгэрэнгүй мэдээлэл авах эсвэл асуулт байвал Grata Интернэшнл хуулийн фирмийн Партнер В.Болормаагийн bvolodya@gratanet.com хаягаар эсвэл 976 70155031 утсаар холбоо барина уу.